

## **НИЙСЛЭЛИЙН НУТАГ ДЭВСГЭРТ НОХОЙ, МУУР БҮРТГЭХ, ЭЗЭНГҮЙ НОХОЙ, МУУРНЫ ТООГ БУУРУУЛАХ ЖУРАМ**

### **Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Нийслэлийн нутаг дэвсгэрт иргэдийн аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, нохой, муурыг бүртгэх, эзэнгүй нохой, муурны тоог бууруулах ажлыг зохион байгуулахтай холбоотой харилцааг энэхүү журмаар зохион байгуулна.

1.2.Галт зэвсгийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасны дагуу тухайн дүүргийн Засаг дарга золбин нохой, муурыг хотын төв, суурин газарт галт зэвсэг ашиглан тоог бууруулах шийдвэрийг биелүүлэх, зохион байгуулан ажиллана.

1.3.Нийслэлийн нутаг дэвсгэрт, хотын төв, суурин газарт хариуцах эзэнгүй золбин нохой, муурын тоо толгойг бууруулах арга хэмжээг Галт зэвсгийн тухай хууль, энэхүү журмын дагуу гүйцэтгэнэ.

1.4.Золбин нохой, муурыг галт зэвсэг ашиглан тоог бууруулах ажлыг дүүргийн Засаг дарга, Улаанбаатар хотын Захирагчийн алба хяналт тавьж, удирдан зохион байгуулан ажиллана.

1.5.Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог Галт зэвсгийн тухай хууль, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасан утгаар ойлгож, журмыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Үндсэн хууль эдгээр хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, стандартуудыг мөрдлөг болгоно.

1.6 Цэргийн болон цагдаа, тагнуул, онцгой, гааль, татвар, бусад төрийн тусгай чиг үүрэг гүйцэтгэх газарт харьяалагдах албаны нохойтой холбоотой харилцаанд энэ журам үйлчлэхгүй.

### **Хоёр. Төрийн байгууллагын эрх, үүрэг**

#### **2.1 Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны эрх, үүрэг;**

2.1.1 Улаанбаатар хотын хэмжээнд нохой, муурыг бүртгэх ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

2.1.2 Нохой, муурыг нэгдсэн бүртгэлийн системд оруулах, эзэнгүй нохой, муурын тоог бууруулах үйл ажиллагаа эрхлэх байгууллага, аж ахуйн нэгжийг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас сонгон шалгаруулж, гэрээ байгуулан ажиллана.

2.1.3 Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба нь “эзэнгүй нохой, муурны тоог бууруулах гэрээ”-ний захиалагчийн хяналтыг сонгон шалгаруулалт хийх замаар гэрээний үндсэн дээр иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.

2.1.4 Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон тариф болон гэрээнд заасны дагуу эзэнгүй нохой, муурны тоогоор санхүүжилтыг олгоно.

2.1.5 Захиалагчийн хяналт гүйцэтгэх иргэний нийгмийн байгууллагыг эзэнгүй нохой, муурны тоог бууруулах үйл ажиллагааны зардлын 2 хүртлэх хувиар санхүүжүүлэх ба санхүүжилтыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба хянаж, олгоно.

#### **2.2.Цагдаагийн байгууллагын эрх, үүрэг;**

2.2.1 Золбин нохой, муурны тоог бууруулах үйл ажиллагааны арга аргачлал, технологийн горим, аюулгүй ажиллагааны заавар, журмын хэрэгжилтэд Улаанбаатар хотын цагдаагийн байгууллага хяналт тавьж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

2.2.2 Хотын төв, суурин газарт галт зэвсэг ашиглан золбин нохой, муурны тоог бууруулах ажилд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, журмыг хэрэгжүүлэх ажилд хяналт тавих,

2.2.3 Галт зэвсгийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан иргэнийг гэрээгээр ажиллуулж буй эсэхэд хяналт тавих.

2.2.4 Иргэн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомж болон галт зэвсэг, ангийн хэрэгсэлтэй ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгч ажиллах, биелэлтэд хяналт тавих.

2.2.5 Гэрээгээр ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдийн үйл ажиллагаанд шалгалт хийж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, шаардлагатай гэж үзвэл гэрээг цуцлах саналыг холбогдох байгууллагад хүргүүлэх.

2.2.6 Хот, суурин газарт галт зэвсэг ашиглан золбин нохой, муурны тоог бууруулах гэрээ, галт зэвсэг, сумны талаарх мэдээлэл(бууны гэрчилгээ, зохих зөвшөөрөл бүхий газраас сум, хэрэгсэл худалдан авсан тухай баримт гэх мэт), бусад бичиг баримтыг шалгах, танилцах, хяналт тавих.

2.2.7 Хуулийн этгээдэд энэхүү журмаар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэн ажиллах талаар мэдэгдэл хүргүүлэх, биелэлтийг тооцох.

2.2.8 Тайланг хагас, бүтэн жилээр холбогдох газар, хуулийн этгээдээс гаргуулан авах.

### **2.3 Дүүрэг, хорооны Засаг даргын эрх, үүрэг;**

2.3.1 Хорооны засаг дарга эзэнтэй нохой, муурны нэгдсэн бүртгэл, пайз дугаар олгох өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах, бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлт оруулах ажлыг хариуцан зохион байгуулж [manaikhoogo.mn](http://manaikhoogo.mn) цахим бүртгэлд бүртгэнэ.

2.3.2 Нохой, муурны бүртгэл, пайз, дугаар олгох ажилд хөндлөнгийн Төрийн бус байгууллагыг татан оролцуулж болох бөгөөд тус шийдвэрийг Улаанбаатар хотын захирагчийн албанаас гаргана.

2.3.3 Бүртгэсэн нохой, муурыг энэхүү журамд заасан шаардлагын дагуу тэжээх, эрүүл мэндийн үзлэгт хамруулах, вакцин, туулга хийлгэх, үржлийг хязгаарлах арга хэмжээ авч байгаа эсэхэд хяналт, шаардлага тавьж ажиллана.

2.3.2 Эзэнгүй нохой, муурын тоог бууруулах үйл ажиллагааны өдөр тутмын хяналтыг хорооны Засаг дарга, хэсгийн ахлагч тавьж ажиллана.

2.3.4 Дүүргийн Хот тохижилтын асуудал хариуцсан хэлтэс болон хорооны Засаг дарга аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс ирсэн мэдээллийн дагуу эзэнгүй золбин нохой, муурны тоог бууруулах ажлыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албатай гэрээтэй устгалын байгууллага, аж ахуйн нэгжид дуудлага өгч гүйцэтгүүлнэ.

2.3.5 Журамд заасан хугацаанд тайланг дээд шатны байгууллагад хүргүүлэх.

2.3.6 Эзэнгүй золбин нохой, муурны тоог бууруулах өдөр тутмын үйл ажиллагаанд хорооны Засаг дарга, Хэсгийн ахлагч нар нь устгуулах шаардлагатай нохой, муурны талаарх мэдээллээр хангаж, хяналт тавьж, дэмжлэг үзүүлэн ажиллана.

2.3.7 Нохой, муурын үржлийн үе болон тоо ихсэх үед дүүргийн Хот тохижилтын асуудал хариуцсан хэлтэс болон хорооны Засаг дарга байгууллага, аж ахуйн нэгж, иргэнээс ирүүлсэн мэдээлэл, хүсэлтийн дагуу эзэнгүй золбин нохой, муурны тоог бууруулах ажлыг эрчимжүүлсэн нэгдсэн арга хэмжээг Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын алба, Цагдаагийн байгууллагаас хамтран зохион байгуулж болно.

2.3.8 Нэгдсэн ажиллагааг аюулгүй ажиллагааны зааварт заасны дагуу зохион байгуулах, хүний эрүүл мэнд, орчинд аюул учруулахгүй, холбогдох иргэн, хуулийн этгээд, байгууллагуудад энэ талаарх мэдээллийг өгч ажиллах.

2.3.11 Энэ журамд заасан бусад үүрэг.

### **2.4. Мал эмнэлэгийн эрх, үүрэг;**

2.4.1 Мал эмнэлгийн байгууллага нь тэжээвэр нохой, муурны бүртгэлийн дугаарыг үндэслэн нэг удаагийн үнэ төлбөргүй эрүүл мэндийн үзлэг хийж эрүүл мэндийн дэвтэр олгох ажлыг зохион байгуулна.

2.4.2 Нохой, муурын урьдчилан сэргийлэх тарилга, вакцин хийсэн болон үзлэг шинжилгээ хийж нохой, муурны эрүүл мэндийн дэвтэрт тэмдэглэл үйлдэж баталгаажуулх

2.4.3 Нохой, мууранд урьдчилан сэргийлэх тарилга, вакцин хийсэн болон үзлэг шинжилгээ хийсэн талаарх бүртгэл хөтөлж, мэдээллийн сан үүсгэх

2.4.4 Эзэнтэй нохой, муур үхсэн тохиолдолд нохой, муурны сэг зэм устгалын байгууллагад хүлээлгэн өгч устгуулах.

2.4.5 Нохой, муурыг үргүйжүүлэх ажлыг иргэн аж ахуйн нэгж байгууллагын хүсэлтийн дагуу түргэн шуурхай зохион байгуулах

## **2.5. Иргэн, аж ахуйн, нэгж, байгууллагын эрх, үүрэг;**

2.5.1 Тэжээвэр нохой, муурыг хүзүүвчтэй байлгах, мэдээллийн санд бүртгүүлэх, эрүүл мэндийн дэвтэр авах, өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга, үзлэг, шинжилгээнд хамруулах.

2.5.2 Нохой, муурыг тэнэмэл, золбин болгох, хаяж төөрүүлэхгүй, зэрлэгшүүлэхгүй байх.

2.5.3 Золбин нохой, муурны талаарх мэдээллийг хорооны Засаг даргад мэдэгдэх

2.5.4 Тэжээвэр нохой, мууранд зориулалтын хүзүүвч, дугаарлалт бүхий пайз зүүлгэх.

2.5.5 Нохой, муур эзэмшигч нь дараах аюулгүйн шаардлагыг баримтална:

а/ Нохой, муурыг орон сууц, гэр хорооллын хашаанд тусгайлан бэлтгэсэн байр, талбайд уяатай байлгах.

б/ Гэр хороололд нохой, муур тэжээх тохиолдолд хашаанаас нохой, муур гарахгүй байх, гаднаас нохой, муур орохгүй байх нөхцлийг хангасан байх.

в/ Нохой, муурыг нийтийн эзэмшлийн гудамж зам, талбай, олон нийтийн газарт хошуувч болон уяатай байлгах, бусдад гэмтэл учруулахгүй арга хэмжээ авсан байх.

г/ Гэр хороололд нохой, муур тэжээх тохиолдолд “Анхаар нохойтой” тэмдэглэгээг харагдахуйц байдлаар хашааны хаалган дээр байршуулах

д/ Орон сууцанд нохой, муур тэжээх тохиолдолд оршин суугчдын аюулгүй тайван амьдрах нөхцлийг алдагдуулахгүй байх,

2.5.9 Нохой, муур эзэмшигч нь дараах ариун цэврийн шаардлагыг баримтална:

а/ Нохой, муурны байр, хэвтэр, уяа, идүүрийг тогтмол цэвэр байлгах.

б/ Нохой, муурны байр, хэвтэр, эдлэл хэрэгслийг ариутгаж, халдваргүйжүүлэх.

в/ Нохой, муурыг тогтмол хугацаанд усанд оруулах.

г/ Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбай, орон сууцны дундын өмчлөлийн явган болон цахилгаан шат, орц, хонгицыг нохой, муурны ялгадсаар бохирдуулахгүй байх ба бохирдуулсан тохиолдолд уут, саванд хийж, орчныг цэвэрлэн, зориулалтын хогийн цэгт хаях.

2.5.10 Эрлийз, үүлдэр угсаа тодорхойгүй нохой, муур тэжээх, болон үржүүлэхээс бусад тохиолдолд мал эмнэлгийн байгууллагаар үргүйжүүлэх ажиллагаа хийлгэсэн байх.

2.5.11 Тэжээвэр нохой, муурыг жилд 1 удаа мэргэжлийн мал эмнэлгийн байгууллагаар тарилга вакцин хийлгэж, үзлэг, шинжилгээнд хамруулсан байна.

2.5.12 “manaikhoroo.mn” сайтад нохой, муурыг бүртгүүлэх.

**Гурав. Нохой, муурыг бүртгэх**

3.1 Эзэнтэй нохой, муурыг нийслэлийн хэмжээнд нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгэж пайз олгох ажлыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба нэгдсэн удирдлагаар хангаж зохион байгуулна.

3.2. Нохой, муурны анхан шатны бүртгэлийг хорооны Засаг дарга, хөндлөнгийн төрийн бус байгуул лага гүйцэтгэж бүртгэл, мэдээллийг manaikhoroo.mn сайтад оруулна. Цахим бүртгэлд нохой, муурны нэр, өнгө зүс, нас хүйс, гарал үүсэл, эзэмшигчийн нэр, хаяг, холбогдох утас зэргийг оруулна.

3.3 Шинээр бүртгүүлж, дугаар пайз авсан нохой, муурыг бүртгүүлснээс хойш ажлын 7 хоногийн дотор мал эмнэлэгийн байгууллагад хандаж эрүүл мэндийн дэвтэр авна. Мал эмнэлэг дугаарлалт бүхий пайзыг үндэслэн “Эрүүл мэндийн дэвтэр”-ыг олгоно.

3.4 Нохой, муурны бүртгэлийн дугаар пайз нь дүүргийн нэрийн товчлол, хорооны дугаар, 6 оронтой дэс дараалсан шифртэй, дахин давтагдашгүй дугаарлал бүхий байна.

3.5 Нохой, муурны эрүүл мэндийн дэвтэр нь нохойны нэр, зураг, гарал үүсэл /удмын талаарх мэдээлэл/, өнгө зүс, үүлдэр, эзний нэр, эзний хаяг, утасны дугаар, шилжилт хөдөлгөөний мэдээлэл, урьдчилан сэргийлэх тарилга, үзлэгт орсон тэмдэглэл, эзэмшигчийн үнэлгээ зэрэг мэдээллийг агуулсан байна.

3.6 Нохой, муур эзэмшигч нь нохой, муурыг төрснөөс хойш 1 сарын дотор бүртгүүлж, нохой, муурны пайзыг хорооноос, пайз авснаас хойш 7 хоногийн дотор мал эмнэлгийн байгууллагаас эрүүл мэндийн дэвтэр авна.

3.7 Нохой, муурны бүртгэл хийлгэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

1. Нохой, муур эзэмшигчийн иргэний үнэмлэх

2. Гарал үүслийн бичиг

3.8 Нохой, муурны эзэмшигч нь солигдсон, нас барсан, нас барсанд тооцогдсон, сураггүй алга болсон тохиолдолд 30 хоногийн дотор хорооны Засаг даргад мэдэгдэж, бүртгэлээс хасуулах эсхүл бүртгэлийг шинэчлүүлнэ.

3.9 Нохой, муур алдагдсан тохиолдолд 24 цагийн дотор харьяа хорооны Засаг даргад мэдэгдэнэ.

3.10 Хорооны Засаг дарга нь нутаг дэвсгэрийн хэмжээнд нохой, муурны тооллогыг жилд нэг удаа жил бүрийн 11 дүгээр сарын 30-ны дотор захиргааны статистик мэдээний маягтаар өрхийн болон байгууллага, аж ахуйн нэгжийн жагсаалтаар дүүргийн Засаг даргын Тамгын газрын статистикийн асуудал хариуцсан нэгжид хүргүүлэх ба дүүргийн Засаг даргын тамгын газар 12 дугаар сарын 5-ны дотор нийслэлийн статистик тоо, мэдээлэл хариуцсан төрийн захиргааны байгууллага болон Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд тус тус хүргүүлнэ.

3.11 Эзэнтэй нохой, муурны тооллогыг жил бүрийн 12 дугаар сард нийслэлийн статистик тоо, мэдээлэл хариуцсан төрийн захиргааны байгууллага Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулна.

3.12 Нохой, муурны мэдээлийн санг цаасан болон цахим хэлбэрээр бүртгэл үүсгэх бөгөөд бүртгэлийг хорооны Засаг дарга, хөндлөнгийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлнэ.

3.13 Энэхүү журмын 3 дугаар зүйлийн 3.4-д заасан бүртгэлийн дугаар нь нохой, муурны хүзүүвч, пайзад давхар тэмдэглэгдсэн байна.

3.14 Тусгайлан зориулагдсан газарт нохой, муурыг үржүүлсэн тохиолдолд мэдээллийн сан үүсгэж, энэхүү журмын 3 дугаар зүйлийн 3.2, 3.4-д зааснаар цахим санд мэдээллийг оруулж, харъяалах хорооны Засаг даргад бүртгүүлэх үүрэг хүлээнэ.

**Дөрөв. Эзэнгүй нохой, муурыг  
түр саатуулах, тоог бууруулах.**

4.1 Нийслэлийн нутаг дэвсгэр, нийтийн эзэмшлийн гудамж талбай, олон нийтийн газар харгалзах эзэнгүй явж байгаа нохой, муурыг эзэнгүй нохой, муур гэж тооцон иргэдийн аюулгүй байдлыг хангах үүднээс барьж саатуулах болон устгах хүртэл арга хэмжээг авч ажиллана.

**4.2 Эзэнгүй нохой, муурыг дараах хэлбэрээр саатуулж, устгана;**

4.2.1 Нийтийн эзэмшлийн гудамж талбайд эзэнгүй явж байгаа нохой, муурыг тухайн байршлаас зориулалтын уурга, тор хэрэглэн барьж, түр саатуулах байранд хүргэнэ.

4.2.2 Эзэнгүй нохой, муурыг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас тогтоосон тарифаар өгсөн дуудлагын дагуу худалдан авч түр саатуулах байранд хүргэнэ.

4.2.2 Түр саатуулсан нохой, муурны мэдээллийг 24 цагийн хугацаанд олон нийтэд мэдээлж эзэн нь тодорхойгүй тохиолдолд устгалд оруулна.

4.2.3 Мэдээлэл тавьснаас хойш 24 цагийн дотор тэжээгч нь ирсэн, болон урьдчилан ямар нэг байдлаар мэдэгдсэн нохой, муурыг устгалд оруулахгүй бөгөөд эзний биеийн байцаалтыг үндэслэн хүлээлгэж өгнө.

4.2.4 Тэжээгч нь нохой, муурны түр саатуулах байрны зардлыг хариуцна.

4.2.5 Зайлшгүй шаардлагатай тохиолдолд тухайн байршил дээр галт сумаар устгаж болно.

4.2.6. Бусад тохиолдолд хуулиар зөвшөөрсөн хүнлэг энэрэнгүй арга хэрэгслийг сонгож гүйцэтгэнэ. Үүнд:

а/ Агааргүйжүүлэх,

б/ Эм тариагаар унтуулах

в/ бусад

7. Устгалд оруулж байгаа нохой, муурын түр саатуулах байр болон тоог бууруулах ажлын зардлыг гэрээний үндсэн дээр Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас гүйцэтгэлээр санхүүжүүлнэ.

**4.3 Золбин нохой, муурны тоог бууруулах үйл ажиллагаа эрхлэх байгууллага, аж ахуйн нэгж дараах шаардлагыг баримталж ажиллана.**

4.3.1 Зориулалтын багаж хэрэгсэл болон цагдаагийн байгууллагад бүртгэлтэй буу, зэвсэг ашиглах

4.3.2 Нохой, муурыг битүү, зориулалтын тээврийн хэрэгслээр ачиж, тээвэрлэх

4.3.3 Нохой, муурыг гэмтээхгүй барьж, саатуулах тусгай бага хэрэгсэл /тор, уурга гэх мэт/

4.3.4 Золбин нохой, муурын тоог бууруулах үйл ажиллагаанд аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол баримталж ажиллах.

4.3.5 Эзэнгүй нохой, муурыг түр саатуулах зориулалтын байр, байгууламжтай байна. Байхгүй бол энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж болно.

4.3.6 Нохой, муур түр саатуулах, устгуулах талаар байгууллага, аж ахуйн нэгжээс ирсэн хүсэлтийг түргэн шуурхай шийдвэрлэх. /түр саатуулсан, устгал хийсэн актыг дуудлага өгсөн иргэн, хуулийн этгээдээс тодорхойлолт авна./

**4.4 “Эзэнгүй нохой, муурны тоог бууруулах гэрээ” байгуулсан иргэн, аж ахуй, нэгж байгууллагын үүрэг:**

4.4.1 Золбин нохой, муурыг тоо толгойг бууруулах аж ахуйн нэгжид ажиллаж байгаа иргэн нь Галт зэвсгийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасан “21 нас хүрсэн, иргэний эрх зүйн бүрэн чадамжтай, галт зэвсэг ашиглаж гэмт хэрэг санаатай

үйлдэж байгаагүй, галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан Монгол Улсын иргэн байна.

4.4.2 Агнах арга, цаг хугацаа, техник хэрэгслээ орон нутгийн онцлог, нөхцөл байдалд тохируулан зөв сонгох, эзэнгүй золбин нохой, муурыг устгах үйл ажиллагааг аюулгүй байдлыг бүрэн хангасан тохиолдолд явуулах. (Дуу намсгагчтай дурантай буу ашиглах, хүүхэд, хүн харах боломжгүй байршилд буудлага үйлдэх)

4.4.3 Эзэнгүй нохой, муурын тоог бууруулах үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн ажилтан нь Галт зэвсгийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

4.4.4 Устгалын ажил явуулахын өмнө нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад биечлэн ирж холбогдох гэрээ, галт зэвсэг, сумны талаарх мэдээлэл (бууны гэрчилгээ, зохих зөвшөөрөл бүхий газраас сум, хэрэгсэл худалдан авсан тухай баримт) бусад бичиг баримтыг танилцуулж, аюулгүй ажиллагааны зааварчилгаа заавал авна.

4.4.5 Тоог бууруулсан эзэнгүй нохой, муурыг цаг тухай бүрт нь хүлээлгэн өгч холбогдох тооцоог хийх, ажлын тайланг Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албанд сар бүр гаргаж өгнө.

4.4.6 Улаанбаатарын хотын Захирагчийн Ажлын албатай байгуулсан гэрээнд заасан үүргийг биелүүлэх, холбогдох тайланг хугацаанд нь хүргүүлнэ.

#### **Тав.Хариуцлага**

5.1 Хууль тогтоомж болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд, иргэн холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

5.2 Иргэн, хуулийн этгээд гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн, галт зэвсгээр сум алдаж бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулсан бол холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээнэ.

